

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2021-09-30/**

Ажлын хэсгийн 56 дугаар хуралдаан 2021 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн 09.30 цагт цахим хэлбэрээр зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож, УУХҮЯ-ны Хөрөнгө оруулалт, судалгааны газрын дарга Э.Батболд, шинжээч Г.Мишээлт, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Татварын ерөнхий газрын байцаагч Э.Батцэнгэл, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн П.Золзаяа, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч Т.Мөнхзул, Рио Тинто Монгол ХХК-ны менежер Даваасүрэн, Бадрах энерги ХХК-ны ЭМХАБОТХ-ийн асуудал хариуцсан захирал Ц.Энхжаргал, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн Д.Сүхбаатар, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Их баяншарга ТББ-ын тэргүүн Л.Бор, Транспаренси Интернэйшнл Монгол байгууллагын менежер Мөнхжаргал болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 18 гишүүн оролцож, ирц 54,5 хувьтай байв.

Мөн хуралдаанд ББЗХ менежер Н.Дорждарь, ажилтан Н.Золжаргал, судлаач С.Борбил, Лидер Вишн групп ХХК-ийн захирал Д.Жанчив, Хүний хөгжил, судалгаа, сургалтын төвийн гүйцэтгэх захирал Г.Цэрэнжаргал, ОУЗСТ-ийн зохицуулагч З.Баярхүү, Мэдээлэл технологийн зөвлөх В.Нармандах, харилцааны мэргэжилтэн З.Цэлмэг, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны газрын дарга Э.Батболд нээж, хурлыг удирдан явуулав.

Э.Батболд: Сайн байцгаана уу, ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүд, нийт оролцогч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид 2021 онд олон ажлыг хийхээр төлөвлөсөн байсан боловч зарим ажлууд цар тахлын улмаас хойшлогдож байна. Энэ оны эхний 9 сард 19 зорилт бүхий 61 ажлыг хийхээр төлөвлөсөн, үүнээс Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төслөөс бусад нь хэрэгжих шатандаа явж байна. ОУИТБС-ын Олон улсын хэлтэстэй хамтарч Эцсийн өмчлөгчийг ил тод болгох тухай сургалт семинарыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн өнөөдрийн хуралдаанаар ОУИТБС-ын мэдээллийг авилгын эрсдэлийг тодорхойлоход ашиглах суурь судалгааны ажлын тайлан, ОУИТБС-ын цахим системийг сайжруулах гэрээт ажлын явц, ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, чадавх хэрэгцээний суурь судалгаа ажлын явцын талаарх мэдээллийг сонсоно, өнөөдрийн хуралдаанд амжилт хүсье, Баярлалаа.

Ш.Цолмон: Сайн байна уу, өнөөдрийн хурлын хөтөлбөрийн бусад асуудлын хүрээнд 2015 оноос хойш ОУИТБС-ын тайлан гаргаагүй компани төрийн байгууллагуудын талаар мэдээллийг МТ зөвлөх Нармандах танилцуулахаар бэлтгэсэн байна, ажлын хэсэг дээрээ танилцуулаад цаашид ямар арга хэмжээ авах талаар ярилцах саналтай байна. Гишүүд саналаа өгнө үү.

Дээрх саналыг гишүүд дэмжив.

**Танилцуулга нэг: ОУИТБС-ын мэдээллийг авилгын эрсдлийг тодорхойлоход ашиглах судалгааны ажлын тайлан.**

С.Боргил: Сайн байцгаана уу, Бид Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгээс боловсруулсан аргачлалын дагуу “Олборлох салбар дахь авлигыг оношлох нь” судалгааны ажлыг хийж байна. Эхний үр дүнг 2021 оны 6 сарын 28-ны өдрийн олон талт оролцогчдын уулзалтад танилцуулж судалгааны дөрөв дэх үе шатанд энэ салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны хүрээ гэсэн чиглэлээр нарийвчилсан судалгаа хийхээр сонгосон. Авилга өөрөө далд явагддаг учраас тусгайлсан судалгааны арга гэж байхгүй, бид төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын хүмүүс болон энэ талаар өмнө нь судалгаа авч байсан судлаачидтай ярилцлага, уулзалт хийх замаар судалгааны ажлын гол мэдээллийн баазыг бүрдүүлсэн байгаа.

Судалгаанд оролцсон хүмүүсийн мэдээллээс анх 12 төрлийн авилгын эрсдэл байна гэж гаргаж ирээд үүнийгээ дахин ангилалд оруулаад 7 төрлийн авилгын эрсдэл байна гэж тодорхойлсон. Үүнд: 1) Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай (хайгуулын, ашиглалтын, олборлолтын, борлуулалтын, тээвэрлэлтийн) тусгай зөвшөөрөл олгох, үнэлгээ, тайлан, төлөвлөгөө хүлээн авах болон дүгнэлт гаргахтай холбоотой авлига; 2) Төрийн өмчит компани (ТӨК)-ийн худалдан авалт, туслан гүйцэтгэлтэй холбоотой авлига; 3) Төрийн албан хаагчийн хяналт, хариуцлагын тогтолцоотой холбоотой үүсэх авлига; 4) Татвар төлбөрөөс зугтах, үүргээ биелүүлэхээс зайлсхийхтэй холбоотой авлига; 5) Компаниуд шударга өрсөлдөөнөөс зайлсхийхтэй холбоотой авлига; 6) Орон нутгийн удирдлага, эрх хэмжээнээс шалтгаалан үүсэх авлига; 7) Процесс хурдавчлах авлигыг тогтоож, дээрх 7 төрлийн эрсдэлийн талаар 2021 оны 9 сарын 8-ны өдөр ажлын дэд хэсгийн хурлаар танилцуулсан. Эдгээр 7 төрлийн эрсдэлийг үнэлгээний хэрэгслийн дагуу эрэмбэлж (i) энэ төрлийн авлига цаашид үргэлжлэх магадлал, (ii) үзүүлэх сөрөг нөлөөлөл, (iii) өөрчлөлт хийх боломж гэсэн гурван шалгуурын дагуу оролцогчид 1 ээс 5 хүртэлх оноо өгч үнэлэх байдлаар хамгийн өндөр авсан дараах 3 эрсдэлийг сонгосон. Үүнд: Төрийн албан хаагчийн хяналт, хариуцлагын тогтолцоотой холбоотой үүсэх авлигын эрсдэл; Компаниуд шударга өрсөлдөөнөөс зайлсхийхтэй холбоотой авлигын эрсдэл; Орон нутгийн удирдлага, эрх хэмжээнээс шалтгаалан үүсэх авлигын эрсдлийг сонгов.

Үнэлгээний хэрэгслийн дагуу 6 дахь буюу хамгийн сүүлийн үе шатанд дэд ажлын хэсгийн сонгосон 3 төрлийн эрсдэл дээр ажлын төлөвлөгөө боловсруулсан. Судалгааны үр дүнд Нэгдүгээрт, тулгамдаж буй 3 төрлийн авилгын эрсдэлийн чиглэлээр 2022 оны ажлын төлөвлөгөөнд тодорхой үйл ажиллагааг тусгах. Хоёрдугаарт, Авилгын эрсдэлийн бусад төрөлтэй холбоотойгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллах гэсэн зөвлөмж гаргасан байна. Баярлалаа. (танилцуулгыг хавсаргав)

Д.Цэрэнжав: Төрийн албан хаагчийн ажил үүрэгтэй холбоотой асуудлаар тусгай зөвшөөрөл, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийг ил тод болгох ажил хийх нь зүйтэй гэсэн санал байна. Мөн компани хувийн хэвшлүүд өөрсдийн бизнесээ хамгаалж үлдэх дээр энэ чиглэлээр ажилладаг хэвлэл мэдээлийн ажилтан, сэтгүүлчидтэй хамтран ажиллах, орон нутгийн мэдээллийг ил

тод болгохын тулд ОУИТБС-ын тайлангаар гарч байгаа мэдээллийг сум, сумаар гаргадаг болгох боломжтой болгох нь илүү үр дүнтэй байна. Тайланд байгаа мэдээллийг ашиглахад хүндрэлтэй байдаг, бэлэн байгаа мэдээллийг нэг товч дараад өөрийн сумын мэдээллийг нэгтгээд авдаг боломжтой болгоход цаашид анхаарна уу гэсэн саналтай байна. Энэ саналууд нь судалгааны үндсэн дээр гарсан учраас техник тал руу ажиллавал илүү үр дүнтэй байх болов уу.

Төрийн байгууллагаас олгодог тусгай зөвшөөрөл, байгал орчинд нөлөөлөх байдлыг эрсдлийн үнэлгээ зэрэг мэдээллийг төрийн нууц, хязгаарлагдмал гэсэн ангилалд хамруулах нь буруу яагаад гэвэл нийтийн баялагийг ашиглаж байгаа учраас ил тод байх хэрэгтэй. Авилгатай тэмцэх ажлын хүрээнд тодорхой санал болгож оруулч өгвөл санаачилгын цаашдын ажилд хэрэг болох болов уу гэж бодож байна. Баярлалаа.

З.Баярхүү: Боргил судлаачаас дараах асуултыг асууя. Авилгатай тэмцэх газар авилгын эрсдэлийг тодорхойлохдоо манай тайлангийн тоон мэдээллийг ашиглах боломж байгаа юу? Ийм мэдээлэлд авилга байх эрсдэл байна гэж талаар гаргаж болох уу? Бид ОУИТБС-ын тоон мэдээллийг ашиглалтыг сайжруулахаар зорьж байгаа. Тайлан гаргасан компаниудын зөрүүгийн талаар аудитын компаниуд тодруулж мэдээлэл авдаг, зарим зөрүү нь хэвээрээ үлддэг энэ нь авилгын агуулгатай байж магадгүй. Мөн хандивын мэдээллийг хандив өгсөн нь тайлагнаад, авсан нь тайлагнахгүй байдаг. Үүнийг аудитын компани тодруулахыг оролддог ч зарим нь хариу өгдөггүй зөрүүгээрээ үлддэг. Энэ зөрүүний цаана авилга байж болзошгүй гэдэг сэдэл төрж байна, үүнийг Авилгатай тэмцэх газар авилгын эрсдлийг тодорхойлоход ашигладаг байх, мөн эцсийн өмчлөгчийг ил тод болгох тайланг томоохон зарим компаниуд тайлагнахгүй байгаа нь цаанаа ямар нэг улс төрд нөлөө бүхий этгээд байх боломжтой гэсэн сэдэл төрөөд байна. Иймд нэгтгэл тайлангийн дараа ил тод болоогүй мэдээлэл дээр ажилладаг байвал ямар бол гэсэн бодол байна, таны байр суурь ямар байна вэ? Баярлалаа.

С.Боргил: Цэрэнжав гишүүний саналыг бид ажлын хүрээндээ боломжийн хэмжээнд ажлын төлөвлөгөөндөө оруулсан. Төрийн байгууллагын мэдээллийг ил тод байлгах ёстой боловч хэрэгжүүлэхгүй, зарим журам нь хуучирсан шинэчлэгдээгүй байх зэрэг асуудлууд байна. Баярхүүгийн асуулт нь бүхэлдээ АТГ-д хандах асуудал байна. Бидний судалгааны зорилгын дагуу аргачлалын хүрээнд ажлаа хийсэн. Миний бодлоор ОУИТБС-ын мэдээллийг ашиглах боломж бий, АТГ тодорхой хэмжээнд ашигладаг гэж ойлгосон. Харин тэр мэдээллийн дагуу зорьж ажилладаг гэдэгт эргэлзээтэй, байцаагч нар нь маш завгүй байдаг юм байна. Эцсийн өмчлөгчийг ил тод болгоход эхлээд мэдээлдэг болгох, тайлагнадаг гэсэн ойлголтыг бий болгоход дор хаяж 5 жил зарцуулна. АТГ-д таны саналуудыг зөвлөмж хэлбэрээр хүргүүлье. Баярлалаа.

Л.Бор: ОУИТБС-ын тайлан бол сайн тайлан. Энэ тайлангаа харахад улсын төсөвт маш бага хэмжээний орлого төвлөрч байгаа, дөнгөж 20 гаруй тэрбум төгрөг. 1700 гаруй компани ашиглалтын тусгай зөвшөөрөл авчихаад ихэнх нь үйл ажиллагаа явуулдаггүй. Төрөөс гарч байгаа бодлого хуулиа хэрэгжүүлэх, хяналт тавьдаг байх хэрэгтэй. Авилгыг Монгол улс дийлэхээ больсон. Хүний эрх, газрын баялагийг ашиглах эко орчны талаар ямар ч хуулинд байхгүй. Ийм их баялагтай байх, ийм ядуу дорой амьдарч байгаа нь төрийн бодлоготой шууд холбоотой. 2019 оны байдлаар 19 их наяд төгрөгийн ашиг олсоноос улсын төсөвт 6 тэрбум төгрөгийн

орлого орсон гэсэн судалгаа байна. Тусгай зөвшөөрөл гаднынхны халаасаар явсаар байгаад дууслаа.

Хүмүүсийн амьдрал дордож байна, иймд өндөр боловсролтой залуучууд та нар байгалийн баялагаа зөв ашиглах, сайжруулах талаар ажиллах хэрэгтэй байна. Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар дахин олгох болсон гэнэ, энэ нь бөөн авилга байдаг. Хайгуулын зөвшөөрлийг гадны компаниуд авч байна, тэдний мэдэлд орж байна.

Н.Дорждарь: ОУИТБС-ын хүрэн цугларсан мэдээллийг АТГ-д ашиглах талаарх чухал асуудлыг Баярхүү ярьлаа. Бид нээлттэй өгөгдлийг ашиглах талаар олон жил ярьж байна. Өгөгдлөө нээлттэй стандартын хэлбэрээр багцлаад, дататай ажилладаг програмуудад холбож ашиглах боломжтой багц болгох, цаашлаад сургалтын хөтөлбөрт ашиглах боломжийг бий болгох талаар ажиллах нь зүйтэй байх. Цахим тайлангийн системийг сайжруулах ажлын талаарх танилцуулга дээр энэ асуудлыг ярилцах, нээлттэй болгох өгөгдлийг боловсруулах, олон нийтэд хүргэх талаар санхүүжүүлэгч байгууллагууд дэмжин ажиллах байх гэсэн санал байна. ОУИТБС-ын хууль эрхзүйн орчныг тодорхой болгох ажил олон жил яригдаад одоо болтол батлагдаагүй байна. Эрхзүйн орчин нь практикаас хоцроод байгаа иймд энэ тал дээр дорвитой ажлуудыг хиймээр байна. Хуулийн төсөл яриад 10 жил болж байна гэж гаднын хүмүүст хэлэхэд ичгэвтэр байна, үнэхээр яамны эрх мэдэл хүрэхгүй байгаа бол санаачилга нь өөрөө Улсын хуралтайгаа ярих эсвэл яам нь өөрөө шууд ярилцах байдлаар энэ ажлаа эрчимжүүлэх шаардлагатай байна.

С.Боргил: Бор гишүүнтэй санал нэг байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын зөвшөөрлийг орон нутаг өөрсдөө шийддэг, дээрээс хяналт шалгалт байхгүй зэргээс шалтгаалаад орон нутгийн төсөлт орлого хуримтлагдахгүй байна. Тухайлбал, хайрга дайрга зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрлийг орон нутаг олгодог байгаа. Мөн нөхөн сэргээлт хийнэ гэж зөвшөөрөл аваад алт олборлох зэрэг асуудлууд гардаг байна. Дээрх байдлаар улсын төсөвт орох орлого эргэлтгүй болсон байна. Одоо барилгын салбар өндөр өсөлттэй, барилга ихээр баригдаж байна гэж байгаа ч энэ нь нууц байдалд байгаа, тайлан тооцоо гаргадаггүй, орлогоо тайлагнадаггүй уул уурхайн салбараас олсон нууц мөнгийг угаадаг газар болсон байна. Дорждарийн саналтай санал нэг байна.

Бид тайландаа нээлттэй өгөгдлийн платформ гэж оруулсан байгаа. Хэрвээ нээлттэй өгөгдөл дэмжигдвэл мэдээлэл ил тод байдлыг хангаж чадна, ил тод байдал хангагдвал олон нийтийг мэдээллээр хангаж чадна, ингэснээр олон нийтийн хяналт бий болно гэж харж байна.

Авилгын эрсдэлийг тодорхойлох судалгааны ажлын тайланг гишүүд дэмжиж, шийдвэрийн төслийг дэмжив.

**Танилцуулга хоёр: Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулах гэрээт ажлын явц**

Д.Жанчив: Сайн байцгаана уу, Манай Лидер Вишн групп нь ОУИТБС-ын цахим системийг сайжруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцож, шалгарч гэрээ хийсэн. Уг систем нь 2015 оноос хойш ажиллаж байгаа, жижиг биш томоохон мэдээллүүдийг агуулсан систем юм. Тайлангийн систем нь тайлангийн модуль, бүртгэлийн модуль, хүсэлтийн модуль, аудитын модуль, судалгаа шинжилгээний

модуль зэрэг олон модулаар мэдээллийг гаргадаг, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, компаниуд тайлангийн мэдээллийг ашигладаг.

Тайлангийн системийг сайжруулах ажлын хүрээнд анх 18 ажил хийхээр тендер зарласан ч одоо 41 ажлыг нэмж хийхээр нэмэгдээд ажиллаж байна. Систем ажилд орсноос хойш жижиг засварууд тухай үед хийгдэж байсан боловч 5 жилийн өмнөх тухай үеийн программ хангамж, мэдээлэл, соорс кодууд хуучирсан, программын логик, функцүүд дээр алдаа гарсан, компаниудаас тайлан авдаг программ дээр алдаа гарсны улмаас тайлан авч чадахгүй байдалд орсон, программ хийсэн өөрчлөлт шинэчлэлтүүд нь туршилтын тестийн орчин байхгүйгээс турших боломж байхгүй зэрэг зайлшгүй шалтгаануудаар программыг сайжруулах ажлыг хийх болсон. Уг ажлууд хийгдсэнээр дата мэдээллийг бүрэн бүтэн байдал хангагдана, системийн найдвартай хэвийн үйл ажиллагаа хангагдах, үйл ажиллагааны өөрчлөлттэй холбоотой сайжруулалтууд хийгдсэнээр системийн мэдээллүүд ойлгомжтой болно. Бид 2021 оны 7 сарын 19 нд гэрээ хийгээд, ажлын төлөвлөгөө боловсруулаад хуваарийн дагуу хийгээд явж байна, гэрээний дагуу 10 дугаар сарын 19 нд дуусах ёстой байгаа. Бидний хийхээр үлдсэн ажлууд кодчилох, тестлэх ажил хийгдэж байна, үүний дараа суурилуулалт, бета тест, хүлээлгэн өгөх улмаар төслийг хаах ажил байгаа. Гэрээний ажлын даалгаварт хэдийгээр 18 төрлийн ажлын хийхээр тусгасан байсан ч гэрээ хийсний дараа ажлаа эхлээд, системтэй танилцахад зайлшгүй хийхээс өөр аргагүй, зарим ажлыг хийхгүйгээр цааш явах боломжгүй ажлууд байсан учраас бид хийхээр болсон . Ажлын явц 50 хувьтай хийгдэж байна. Бидний хийж байгаа ажлуудыг хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг танилцуулгаас харж болно, мөн хийгдэж дууссан ажлуудыг харуулсан байгаа. Баярлалаа. (танилцуулгыг хавсаргав)

Д.Цэрэнжав: Тусгай зөвшөөрлийн мэдээлэл цаашдаа хэрхэн орох вэ, тусгай зөвшөөрөл өөрчлөгдөхөд шууд өөрчлөгдөх үү эсвэл гараар оруулдаг байдлаар байх уу?

Д.Жанчив: Тусгай зөвшөөрлийн мэдээлэл хуучнаараа татагдана, харин цаашдаа АМГТГ-ын системтэй шууд холбож, мэдээллийг шууд татдаг болох боломжтой болох байх. Үүнийг ажлын алба анхаарах байх.

Л.Бор: Нэгтгэл тайлан гарахаас өмнө АМГТГ-ын тусгай зөвшөөрлийн мэдээллийг улирлаар шууд авах боломж байгаа юу? Ашигт малтмалын газрын мэдээллийг шууд ашиглах боломжгүй байдаг.

В.Нармандах: Лицензийн мэдээллийн өөрчлөлтийг улирал тутам гараар оруулаад авах боломжтой.

Д.Цэрэнжав: ОУИТБС-ын тайлан маань тайлан болон хавсралт хэсгээс бүрддэг. Сүүлийн үед бид хавсралтыг илүү ашиглаж байна. Цахим тайлангийн системд орсон мэдээллийг түүхийдүү байдлаар олон нийтэд зориулсан мэдээлэл байгаа. Хавсралт маш чухал, одоо мэдээлэл тарсан байдалтай байгаа, цаашдаа аймаг сумаар нь ангилж хардаг боломжтой болох тал дээр санаа оноо өгөөрэй, баярлалаа.

Б.Даваасүрэн: Цэрэнжав гишүүний саналыг дэмжиж байна. Бид маш их ажил болгож цуглуулсан мэдээллээ олон нийтэд хүргэх талаар илүү сайн ажиллах хэрэгтэй байх. Үүний тул техникийн ямар арга шийдэл байна түүнийг ашиглах,

мэдээллийг хураангуй болгох, инфографик болгох эсвэл боловсруулах тал дээр ажлын алба цаашид ажиллах хэрэгтэй болов уу гэсэн саналтай байна. Баярлалаа.

В.Нармандах: Бид тайлангийн системийг сайжруулах, нээлттэй өгөгдлийн талаар ажлын албандаа ярилцаж байгаа. Систем сайжруулах ажлын даалгавар энэ оны нэгдүгээр сард боловсруулагдсан бөгөөд үүнээс хойш тайлан авахад маш их асуудал гарсан тул ажлын даалгавар дээр 41 ажил нэмэгдсэн байгаа, Лидер Вишн групп гэрээний хүрээнд нэмж хийхээр болсон. Гэвч хугацаа шахагдаж байгаа учраас Нээлттэй өгөгдлийн програмаар тайлан гаргадаг болгох ажлыг хойшлуулсан байгаа. Олон улсын санхүүгийн корпорацийн тусламжтайгаа нилээн олон мэдээллийг боловсруулаад Нээлттэй өгөгдөл хэлбэрт оруулж байршуулсан байгаа, цаашдаа үүнийг автомат болгох талаар ярьж, төлөвлөж байгаа.

Д.Жанчив. Та бүхэн хавсралт мэдээллээс ямар ч мэдээллийг жагсаалт байдлаар авах боломжтой, харин ийм мэдээллийг ингэж авмаар байна гэсэн үндсэн шаардлагуудаа гаргаад өгвөл техник тал дээр хийхэд маш хялбархан гэж бодож байгаа. Энэ төслийг анх өөр компани хийсэн гэхдээ тэр үед би төслийн багийг ахалж ажиллаж байсан учраас одоо илүү ойлгоод ажиллаж байна. Түүнээс шинэ хүн орж ирээд алдаа дутагдлыг нь олоод шийдвэрлээд явахад амаргүй ажил. Бид гэрээний дагуу 10 сарын 19 нд ажлыг хүлээлгэж өгөх ёстой боловч шаардлагууд нэмэгдсэн болохоор хугацаандаа багтахгүй байх эрсдэлтэй байна гэдгээ илэрхийлье.

Д.Цэрэнжав: Ажлын албанаас зохион байгуулаад, гишүүдээс тайлангийн хавсралт мэдээллийг хэрхэн боловсруулах талаар санал авмаар байна, мөн энэ ажлыг хийж байгаа компанийн хүмүүстэй бас цахимаар ч юмуу уулзаж болно. Үүнийг Мэдээллийн зөвлөх Нармандах зохион байгуулах байхаа.

Д.Жавчив: Ямар ч программ хангамжийг ашиглалтад оруулаад цаашдаа жил бүр хөгжүүлэх, сайжруулах ажлыг хийж явах ёстой байдаг. Тэгэхгүй бол 5 жил ашиглаад өнөөдрийн байдалд хүрнэ. Цаашдаа үүнийг анхаарах хэрэгтэй гэж хэлье, баярлалаа.

В.Нармандах: Жанчивтай санал нэгтэй байна. Ямар ч системийг хийгээд баталгаат хугацаандаа хөгжүүлэлтийг хийгээд явдаг. Энэ хугацаа нь дуусахаар цаашдаа тогтмол засвар үйлчилгээний гэрээ хийгдэж явах ёстой байдаг. Гэтэл “Төрийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д программ хангамжийг зөвхөн компьютер худалдан авах байдлаар тусгасан байгаа нь учир дутагдалтай харагдсан. 14 хоног сар сараар шинэчлэлт хийгдэх ёстой программ маань 2014 оноос хойш юу ч хийгдээгүй учраас одоо шинэчлэл хийхээр хүндрэлтэй нөхцөл байдал үүсгээд байгаа юм. Тэгэхээр хуучин технологи дээрээ шинэчлэлт хийхийн оронд шинэ технологи хийсэн нь дээр юм шиг нөхцөл үүсч байгаа. Энэ нь тогтмол засвар үйлчилгээний гэрээ байхгүйтэй 100 хувь холбоотой юм.

Бүх төрийн байгууллагууд тайлан гаргахдаа өөрийн системээс мэдээллээ аваад манай форматад тааруулж гараар оруулаад дараа нь манай тайлангийн систем руу татаж оруулах замаар тайлан гаргаж байна. Иймд ажиллагааг хөнгөвчлөхийн тулд хөрвүүлэгч систем хийх эсвэл хоёр байгууллагын системийг хооронд нь шууд холбох зэрэг шийдлүүдийг ажлын албан дээр ярьж байгаа. Мөн Цэрэнжав гуайн хэлсэн саналын дагуу системийн сайжруулалтын талаар ажлын хэсгийн гишүүдээс санал авъя.

Л.Бор: Орон нутгийн иргэдэд зориулаад систем дээрээ нэг цэс нэмэх боломж байгаа юу? Би зарим мэдээллээ авч чадахгүй л байгаа.

В.Нармандах: Бид хялбаршуулсан байдлаар хавсралтаас хэрэгтэй мэдээллээ авдаг болгохоор төлөвлөж байгаа, энэ удаагийн сайжруулалтаар арай амжихгүй хойшилж байгаа.

Д.Цэрэнпүрэв: Сайн байцгаана уу, тайлангийн мэдээллийг иргэдэд хүргэхийн тулд системээ сайжруулж байгаад баяртай байна. Мэдээллийг хүргэх бодлогодоо өөрчлөлт оруулмаар санагдаж байна. Баярлалаа.

**Танилцуулга гурав: Монголын ОУИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, чадавх хэрэгцээний суурь судалгаа, мониторинг хийх, үйл ажиллагааг идэвхжүүлэх стратеги, төлөвлөгөө боловсруулах гэрээт ажлын явц**

Г.Цэрэнжаргал: Манай судалгааны төвийн баг дээрх ажилд гэрээ байгуулан ажиллаж байна. Тус судалгааны зорилго нь Монголын ОУИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн бодит байдалд үнэлгээ өгөх, орон нутагт ил тод байдлыг хангахад тулгарч буй бэрхшээл, хэрэгцээг судалж, тодорхойлсны үндсэн дээр тайлан боловсруулж, цаашид дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулахад чиглэсэн зөвлөмж, стратеги, ажлын төлөвлөгөөний төслийг судалгааны хамт Монголын ОУИТБС-ын Олон талт ажлын хэсэгт хүлээлгэн өгөхөд оршино. Бидний ажил ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлага, асуулга, талбар дээр ажиллах, баримт бичгийн судалгаа үүн дээр үндэслээд дүгнэлтээ гаргаад, стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлыг хийх байсан. Талбар дээрх ажлыг Дорноговь, Сэлэнгэ, Төв аймаг болон Бор-Өндөр суманд очиж ажилласан. Судалгаандаа 21 аймгийн дэд зөвлөлийн гишүүдээс санал асуулга авч дүгнэлтийг гаргасан. Дэд зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг судалсан. Үүнд нийт 253 ажлыг хийхээр төлөвлөсөн энэ нь нэг зөвлөл дунджаар 13 ажил гэсэн үг юм. Үүнээс хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавхи бэхжүүлэх 48 ажил, судалгаа мэдээ тайлан гаргах 119 ажил, тайлан мэдээг иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх, төрийн байгууллагын үндсэн чиг үүргийн чанартай, дэд зөвлөлийн чиглэлтэй уялдаагүй 31 ажил байсан.

Дэд зөвлөлүүдийн төлөвлөгөө нь аймаг бүрийн төлөвлөгөөний үйл ажиллагааны чиглэлийн бүтэц ялгаатай, төлөвлөгөөнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, нэр тодорхой бус, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт байхгүй, иргэдэд мэдээлэл өгөх арга хэлбэр нь нутгийн захиргааны цахим хуудсаар хязгаарлагдах, төрийн албан хаагчийн үндсэн чиг үүргийн ажлыг ажлын төлөвлөгөөнд тусгасан байна. Судалгаанд нийтдээ 46 хүн хамрагдсан, удирдлагын түвшний 11, төрийн байгууллагын 23, хувийн хэвшил 1, иргэний нийгмийн байгууллагын 11 хүн байсан. Үүнээс Дорнод аймгийн дэд зөвлөл хамгийн их буюу 16, Баянхонгор аймаг хамгийн бага буюу 4 гишүүнтэй байсан бол дундажаар 10,5 гишүүнтэй байна. Дэд зөвлөлийн бүтцийн харьцаа тэнцвэртэй биш, төрийн байгууллагын төлөөлөл давуу байна. Дэд зөвлөлийн гишүүдийн 56 хувь нь 2020 оны сонгуулийн дараа шинээр ажилд томилогдсон байна. Бид дэд зөвлөлийг судлахаас гадна гадны орны туршлага мөн судалсан байгаа.

Хэдийгээр нийслэл, аймгийн дэд зөвлөл байгуулагдаад 8 жил болж байгаа ч үйл ажиллагаа нь хангалттай тогтворжоогүй, тус санаачилгын талаарх дэд

зөвлөлийн гишүүд болон олон нийтийн мэдлэг мэдээлэл хангалтгүй, тухайн орон нутагт үзүүлж буй нөлөөлөл хангалтгүй гэж дүгнэж, дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд, дэд зөвлөлийн засаглал оновчтой бус, үйл ажиллагааны арга барил, үйл явц хангалттай бүрдээгүй, мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна. Судалгааны үр дүнгээс дараах зөвлөмжүүдийг гаргасан байна.

ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхой болгох, ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд дэд зөвлөлийн нарийн бичгийг даргыг ИНБ-ийн төлөөллөөс томилж, цалин төсөвтэй байхаар баталж өгөх, дэд зөвлөлийн санхүүжилтийг Засгийн газрын тогтоолын дагуу шийдвэрлэхийн зэрэгцээ дэд зөвлөлд тодорхой үйл ажиллагаанд зориулан хөрөнгийн эх үүсвэрийг татаж төвлөрүүлэхийг дэмжих, ОУИТБС-ын дэд зөвлөлийг аргазүй, бусад санаачилга, төсөл хөтөлбөртэй уялдуулах, холбох үйл ажиллагааг Ажлын албанаас системтэй зохион байгуулах, ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг илүү тогтвортой, идэвхтэй болгох зорилгоор “ОУИТБС-ын бүсийн зөвлөл” загварыг турших зэрэг зөвлөмжүүдийг боловсруулсан байна.

Дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах стратеги маань 1) бүтэц зохион байгуулалт, 2) ил тод байдлыг хангах, 3) нөлөөлийн үнэлгээ гэсэн гурван хэсэгтэй. Хэсэг тус бүрийг хэрэгжүүлэх арга зүйнүүдийг саналуудыг боловсруулж, эхний байдлаар стратегийн төслийн боловсруулсан байна. Баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Л.Бор: Судалгааны танилцуулгыг сонслоо, ер нь боломжийн голтой судалгаа, дүгнэлт хийсэн байна. Би өмнө нь дэд зөвлөлийн ажлын чиглэлээр санхүүжилт аваад Сүхбаатар аймгийн дэд зөвлөл болон Сэлэнгэ аймгийн 2 суманд ажиллаж, сургалт хийж байсан, энэ жилийн төлөвлөгөөнд төсөв байсан байх, хэн хэрхэн ашиглаж байгаа талаар ТАН эвсэл мэдээлэл өгөөгүй байна. Тэр үед одоогийнхтой адил Zoom энэ тэр байгаагүй гэхдээ Skype холбогдоод тухайн үед ажиллаж байсан. Ажлын албаны мэдээллийн ажилтан болон харилцааны мэргэжилтэнүүдтэй хамтраад хялбархан байдлаар сургалт хийж байсан. Одоо илүү боломж байгаа, энэ талаар ТАН эвсэл санаачилгатай ажиллавал болох байх, бидэнд санхүүжилтийн талаар мэдээлэл өгдөггүй.

Би саяхан Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сумруу өөрийн зардлаар яваад мэдээлэл өгөөд ирсэн, сургалт хийгээгүй. Нэг хүнд 5 сая төгрөг өгөөд орон нутгийн дэд зөвлөлийг чадавхижуулах, мэдээлэл өгөх ажлыг хийлгэх бүрэн боломжтой. ОУИТБС-ын тайлангаас хэрэгтэй мэдээллээ авч нэгтгээд, иргэдэд зориулсан сонин гаргаад тарааж байгаа, зардлаа өөрөө гаргасан. Үүнээс гадна олон талт зөвлөл гэж Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс орон нутагт байгуулаад байгаа. Энэ нь иргэдийн толгойг эргүүлээд байна. Орон нутгийнхан мэдээлэл сайтай байвал компаниас шаардаад байх боломжтой.

Д.Цэрэнпүрэв: Судалгааны ажлын даалгавартай танилцсан, даалгаврын дагуу сайн хийсэн байна. Маш хэрэгцээтэй, олон талыг хамарсан судалгаа болсон байна. Судалгаанаас гарсан зөвлөмж болон стратегийг хэрэгжүүлэхэд ажлын алба болон ажлын хэсэг санаачилгатай ажиллах нь зүйтэй байх гэсэн саналтай байна, баярлалаа.



## **Танилцуулга дөрөв: Монголын ОУИТБС-ын тайлан гаргаагүй компанийн мэдээлэл.**

Ажлын албанаас сүүлийн 5 жилийн хугацаанд ОУИТБС-ын тайлан гаргаагүй байгууллагуудын мэдээллийг ил болгож, ажлын хэсэгт танилцуулж, цаашид ямар арга хэмжээ авах талаар шийдэх зорилготой. Тайлан гаргаагүй компаниудын тоо 2016 онд 811 байсан бол 2020 онд 677 болсон байна, давтамж нь таван жил дараалан тайлан гаргаагүй компани 126, дөрвөн жил гаргаагүй 294, гурван жил гаргаагүй 1588, хоёр жил дараалан 921, нэг жил тайлан гаргаагүй 488 компани байна үүнээс Сонсголон бармат ХХК хамгийн их буюу дөрвөн жил дараалан тайлан гаргаагүй байна.

Тайлан гаргаагүй төрийн байгууллага 5-6 байна. Тухайлбал 2016 онд Дархан-Уул аймгийн ЗДТГ, Өмнөговь аймгийн ЗДТГ, Увс аймгийн ЗДТГ, Сүхбаатар дүүргийн ЗДТГ, Стандартчилал хэмжилзүйн газар зэрэг 6 байгууллага гаргаагүй байна. 2020 онд Өмнөговь аймгийн ЗДТГ, Сүхбаатар аймгийн ЗДТГ, Сүхбаатар дүүргийн ЗДТГ, Хөдөлмөрийн яам тус тус ОУИТБС-ын тайлан мэдээг гаргаагүй байна.

ОУИТБС-ын тайлан гаргах талаар Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиудад “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөлт төлсөн татвар төлбөрийн хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэж заасан байдаг. Эдгээр заалтуудыг зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авах тухай Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн заалтууд байдаг байна.

Л.Бор: За энэ маш чухал мэдээлэл байна. Ашиглалтын лиценз авчихаад өрмөө ч тавиагүй байгаа компаниуд олон байдаг тэр байтугай 10 жил юу ч хийгээгүй газрууд байдаг. Үүнийг ил тод болгож, хариуцлагатай болгоход энэ маш хэрэгтэй. Иймээс Ашигт малтмалын тухай хуульд зөрчил гаргасан, татвар хураамжаа тайлагнахгүй байгаа компанийн тусгай зөвшөөрлийг хурааж авдаг байх мөн ашиглалтын тусгай зөвшөөрөл аваад ямар ч үйл ажиллагаа явуулахгүй байгаа компанийн зөвшөөрлийг хурааж авах, цуцлах тухай заалт оруулах хэрэгтэй. Тусгай зөвшөөрөл дамын наймаачдын гараар ороод зарагдаад байдаг, хэдийгээр шилжүүлж болохгүй гэж хуулиндаа заасан байдаг ч Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль зөрүүтэй байдгаас хүмүүс хуулийн цоорхойг нь ашигладаг байна. Төрийн байгууллагууд хяналт тавьж чаддаггүй санагддаг.

З.Цэлмэг: Тайлан гаргаагүй компаниудыг байршилаар нь гаргаад цахим сайтад тавих саналтай байна.

З.Баярхүү: Тайлан гаргаагүй компаниудын тухай мэдээлэл хийж байгаа нь үйл ажиллагаа явуулж байгаа боловч сүүлийн жилүүдэд тайлан гаргаагүй компаниудыг ил болгож, цаашид тайлан гаргуулах талаар ямар арга хэмжээ авах талаар ажлын хэсгийн гишүүдийн саналыг авах зорилгоор танилцуулсан. Тайлан гаргаагүй компанийг одоогийн хууль эрхзүйн орчноор 10 сая төгрөгөөр торгоно гэдэг ч яг амьдрал дээр торгож арга хэмжээ авсан тохиолдол байдаггүй юм байна. Тэгэхээр нөгөө компаниудад ямар ч арга хэмжээ авдаггүй болохоор тайлангаа гаргахгүй яваад байдаг.

Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль ойрын үед батлагдахааргүй байгаа. Иймд өөр ямар замаар арга хэмжээ авч, тайлан гаргадаг болгох вэ? жил бүрийн тайлан гаргадаг компаниудын тоог нэмэгдүүлж, 2020 онд 90 хувьд хүргэх зорилт тавьсан гэсэн бас л 60-70 хувьтай л тайлан гаргасан байна. Бид хариуцлага, хууль эрхзүй гэж ярихаар гадна нөгөө талдаа хариуцлагатай ил тод компанийг зарладаг, урамшуулдаг байя гэсэн бодлого баримтлаад, УУХҮЯ-тай ярилцаад энэ талаарх журамд өөрчлөлт оруулаад ажиллаж байна. Цаашдаа тайлан гаргахгүй байгаа компаниудыг яах вэ, ямар арга хэмжээ авах талаар ажлын хэсгийн гишүүдтэй ярилцаад, тайлан гаргадаг болгомоор байна. Ингээд урсгалаараа тайлангаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй яваад байвал яваад л байх болно, иймээс компаниудыг тайлан гаргадаг болгох, хариуцлагатай болгох зорилгоор дээрх танилцуулгыг хийсэн байгаа.

Мөн өнөөдрийн хуралдааны бусад хэсэг хөтөлбөрийн нэмэлт дээр танилцуулахаа мартсан юм шиг байна. Бид өмнөх ажлын хэсгийн хуралдаанд ОУИТБС-ын тайлангийн маягтад өөрчлөлт оруулах тухай саналыг танилцуулсан, дэд ажлын хэсгийг байгуулсан. Дэд ажлын хэсгээсээ санал авсан одоогоор хоёр хүнээс санал ирсэн байгаа. Энэ саналыг маягтын өөрчлөлт дээр нэмж оруулаад, цаашаа Үндэсний ститистикийн хороо руу явуулах ёстой байгаа. Бид 2021 оны 8 сарын 23-нд вэбсайтад маягтаа тавиад олон нийтээс санал хурааж авсан, одоогоор санал ирээгүй байгаа. Олон нийтээс санал авах хугацаа нэг сар байдаг энэ хугацаа маань өнгөрсөн байгаа, шаардлагатай бол бид маягтын өөрчлөлтийн талаар дахин танилцуулж болно, өмнөх хуралдаанаар гишүүдэд танилцуулж байсан. Энэ асуудал дээр та бүхнээс саналаа авах хэрэгтэй байгаа.

Тайлангийн маягтын өөрчлөлтөөр борлуулалт экспорт, цалин, хандив, төлөвлөгөөг ил тод болгох мөн эдийн засагт үзүүлэх нөлөөг ил тод болгох мөн худалдан авалтын талаарх мэдээллийг ил тод болгох нь зүйтэй гэсэн байдлаар ажлын дэд хэсэгт танилцуулаад санал авсан. Ажлын дэд хэсгийн гишүүн Цэрэнпүрэв болон Цэлмэг нараас санал ирсэн, үүнийг нэмж оруулна. Ингээд гишүүдээс өөр саналгүй бол бид маягтаа батлуулахаар Үндэсний статистикийн газар хүсэлтээ явуулах ёстой байгаа та бүхэн дэмжих талаар саналаа өгнө үү.

Л.Бор: Олборлох, уул уурхайн асуудлаар улирал тутам хэвлэл мэдээлэл оролцуулаад болж өгвөл танхимаар хэлэлцүүлэг хийх саналтай байна. Эрдэс баялагийн тухай хуулийн талаар ярилцмаар байна. Нөөцийг нь батласан ордыг барьцаалж, зээл авч байна, ямар ч төлбөр хураамж авахгүй байгаа зэрэг асуудал их байна, энэ талаар бас цувралаар ярихыг санал болгож байна. Уул уурхайн асуудал улам хүнд болоод байна. Уул уурхай, эрдэс баялагийн хуулийг батлахгүй байх шалтгаан байдаг.

Ш.Цолмон: Тайлан гаргаагүй компаниудын мэдээллийг эхний ээлжинд ОУИТБС-ын вэбсайтад байршуулах, тайлангийн маягтийн өөрчлөлтийг Статистикийн газарт хүргүүлж, маягтуудыг өөрчлөх хүсэлтийг УУХҮЯ-нд уламжлах гэсэн байдлаар шийдвэрийн төсөлд оруулахаар болж байна. Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлсэн та бүхэнд баярлалаа, эрүүл энхийг хүсье.

Хуралдаан 13.10 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн  
дарга:

Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:  
УУХҮЯ-ны ХОСГазрын дарга

Э.Батболд

Тэмдэглэлийн хянасан:  
ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын Ажлын албаны  
Санхүүгийн ажилтан

А.Отгонтунгалаг